

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Багц №1: Эмнэлгийн гаралтай аюултай болон эрсдэлтэй хог хаягдал зайлуулах, тээвэрлэх, устгах

Тавигдах шаардлага:

1. 2024 онд дунджаар 35,000 кг эмнэлгийн аюултай болон эрсдэлтэй хог хаягдлыг тээвэрлүүлэх, устгуулах;
2. Тус эмнэлгийн халдвартай хог хаягдлыг түр хадгалах байрнаас ажил гүйцэтгэх хуваарийн дагуу өдөр бүр 9-10 цагийн хооронд битүүмжилсэн шар савтай, аюулгүй хайрцагтай халдвартай хог хаягдлыг жиглэн бүртгэл үүсгэн тээвэрлэх;
3. Өдөр бүр эмнэлгийн аюултай болон эрсдэлтэй хог хаягдлыг жигнэж тэмдэглэл хөтлөн баталгаажуулах. Сар бүрийн 10-ны дотор ажлын гүйцэтгэлийн тайланг ирүүлж баталгаажуулах.

Багц №2: Хортон мэрэгчдийн устгал, ариутгалын ажил

	Ажлын төрөл	Хэм жих нэгж	Гүйцэтгэх талбай нэгж	Хугацаа	Тайлбар
	Шавьжгүйтгэл	мкв	25500	Жилд 2 удаа	Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хурц үнэргүй, байгаль орчинд аюулгүй, Монгол улсын стандард MNS 5161-1:2002
	Мэрэгчгүйтгэл	мкв	8800	Жилд 2 удаа	стандартын дагуу худалдан авч, MNS5161-2:2002 стандартын дагуу бэлтгэсэн байх

Тавигдах шаардлага:

1. Байгууллагын өрөө, тасалгаа, эзэмшил газруудаар явж ариун цэврийн нөхцөл, түвшинг үнэлж, шавьж мэрэгчийн үүрлэн үрждэг үүр ноохой, дотооддоо болоод гадагш дамжин тархдаг газруудыг тогтоон тэмдэглэх, эзэмшигчээс хортон шавьж мэрэгчийн талаар мэдээлэл авах;
2. Тухайн газарт шавьж мэрэгчийг барих, цуглуулах, наалдуулагчийг байрлуулан, ажил үйлчилгээнд хамаарах талбай, эзэлхүүн, өрөө, тасалгаа, хонгилын тоог гаргах;
3. Илэрсэн шавьж мэрэгчийг тодорхойлон, тархалтын түвшинг тогтоож, хэрэглэх бодисын төрөл, тун хэмжээ үйлчилгээг нарийвчлан тодорхойлж, тандалт судалгааны хуудсанд тэмдэглэх;
4. Тухайн газарт хийгдэх ажил үйлчилгээний талаар үйлчилгээний өмнөх ба дараах технологийн горимын талаар холбогдох хүмүүст танилцуулан, цэвэрлэгээ хийлгэх, хогийг зайлуулах, нүх онгорхойг бөглөх, цахилгаан хэрэгслийг түр салган, эд зүйлсийг хананаас зайтай тавих бэлтгэлийг хангуулах;
5. Үйлчилгээ хийх бодис нь энэ стандартын шаардлага хангасан байна. MNS 5161-1:2002 стандартын дагуу худалдан авч, MNS5161-2:2002 стандартын дагуу бэлтгэсэн байх;